№ 1418

Since 1997
ITZONE
Accelerate Your Success

АЙ ТИ ЗОН ХХК
Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8-р хороо, Бага тойруу 14200, Сүхбаатарын талбай,
Сити Тауэр, 4 давхар
Утас: (+976) 77317731
Үйлчилгээний лавлах: (+976) 77312424
И-мэйл: crm@itzone.mn, Вэб: www.itzone.mn

Дугаар 02/2851

Он 2019 Сар 09 Өдөр 19

Улаанбаатар хот

ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ ХК-ийн

Гүйцэтгэх захирал танаа

Б.Баярмаа-д журмын дагуу шийдвэрлэх. 2019.09.20

Хүсэлт гаргах тухай

"Эрдэнэс-Тавантолгой" ХК-аас зарласан "ERP программ хангамж" худалдан авах ЭТТ/201901144 дугаартай нээлттэй тендер шалгаруулалтад "хамгийн бага харьцуулах үнэтэй" тендер ирүүлэн, гэрээ байгуулах эрх авсан компани нь програм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаггүй компани бөгөөд Тендерийн баримт бичгийн Нэгдүгээр бүлгийн 6.1.(д)-т заасан шаардлагыг хангахгүй оролцогч гэж бид үзэж байгаа тул Монгол улсын Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан "Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам"-ын 2.4 болон 2.5 дахь хэсэгт заасны дагуу уг тендерт шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендерээс ил болгох материалтай танилцах хүсэлтэй байгаа тул бидний хүсэлтийг хүлээн авна уу.

Хүндэтгэсэн,

ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ Б.ЦЭЭСҮРЭН

Ай Ти Зон ХХК ITZONE Улаанбаатар хот

М.Бат-Эрдэнэд холбогдох журмын дагуу хариу өгөх. IX/20

№ 1422

ИНТЕРАКТИВ
**ИНТЕРАКТИВ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ**

Монгол Улс, Улаанбаатар Сүхбаатар дүүрэг, Бага тойруу 49,Мэдээллийн Технологийн Үндэсний Парк 109 тоот, Ш/х-46/440 Утас: 98182633, Факс:320334, E-mail: contact@interactive.mn, http://www.interactive.mn

2019.09.20 № 19/166

танай ____________-ны № ________________-т

**ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК-д**

**Хүсэлт гаргах тухай**

Манай компани танай байгууллагаас зарласан ЭТТ/201901144 тендер шалгаруулалтын дугаар бүхий "ERP программ хангамж" тендер шалгаруулалтад оролцсон бөгөөд 2019 оны 9-р сарын 16-ны өдөр гаргасан захиалагчийн мэдэгдлийг хүлээн авсан.

Манай компанийн зүгээс дараах хүсэлтийг хүргүүлж байна. Үүнд

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49.4-т заасны дагуу тендер шалгаруулалтын материалтай танилцах хүсэлттэй байгаа тул бидний хүсэлтийг хүлээж авч шийдвэрлэж өгнө үү.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журмын дагуу тус тендерт шалгарсан компанийн мэдээллийг ил болгож, тендер шалгаруулалтын үр дүн Худалдан авах ажиллагааны цахим системд нийтэлнэ үү.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БАТТӨР

ИНТЕРАКТИВ ХХК
ХУДАЛДАА ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ
ТТН342 з.2097192

ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ ХК
ТТС = 3695